

**МОНГОЛ УЛС**  
**АЗИЙН ХӨГЖЛИЙН**  
**БАНК**


**МОН 3948 “БҮС НУТГИЙН**  
**ХӨГЖЛИЙН НЭГДСЭН**  
**ТӨЛӨВЛӨЛТИЙН ЧАДАВХИЙГ**  
**БҮРДҮҮЛЭХ НЬ”**  
**ТЕХНИКИЙН ТУСЛАЛЦАА**

**БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖИЙН**  
**БАРИМТ БИЧИГ №7:**  
**БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН**  
**УДИРДЛАГА,**  
**ТӨЛӨВЛӨЛТИЙН БҮТЭЦ**  
**ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

**2004 оны 3-р сар**

# Боловсруулсан:

Бадамгаравын Гантуяа  
Бүтэц зохион байгуулалт хуулийн асуудал  
хариуцсан зөвлөх



АВСТРАЛИЙН Р.Д.Р КОМПАНИ

## ГАРЧИГ

Өмнөх үг.....	1
Бодлогын зөвлөмжийн баримт бичгийн жагсаалт .....	1
Баримт бичгээс гарах зөвлөмжүүд.....	2
<b>1. Бүсчилсэн хөгжлийн удирдлага, төлөвлөлтийн бүтэц зохион байгуулалт .....</b>	<b>4</b>
1.1 Ерөнхий мэдээлэл .....	4
1.2 Бүсчилсэн хөгжлийн удирдлагын бүтэц зохион байгуулалт .....	4
1.3 Бүсчилсэн хөгжлийн төлөвлөлтийн бүтэц зохион байгуулалт .....	6
1.4 Гол байгууллагуудын эрх үүрэг .....	9
1.4.1 Улсын Их Хурал.....	9
1.4.2 Засгийн Газар.....	9
1.4.3 Үндэсний Хороо .....	10
1.4.4 Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газар .....	10
1.4.5 Санхүү Эдийн Засгийн Яам (СЭЗЯ) .....	11
1.4.6 Салбар яамд .....	11
1.4.7 Бүсийн Зөвлөл .....	11
1.4.8 Нийслэл хот, аймгуудын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал .....	12
1.4.9 Нийслэл хот, аймгуудын Засаг дарга нар.....	12
1.5 Бүс нутгийн хөгжлийн асуудалд хувийн хэвшил болон Төрийн Бус Байгууллагуудын оролцоо.....	12
1.6 Үндэсний Хорооны Ажлын Албаны байршил.....	15
<b>2. Бүсчилсэн хөгжлийн удирдлага, төлөвлөлтийн бүтэц зохион байгуулалтад хамаарах хүрээ.....</b>	<b>17</b>
2.1 Төсвийн Байгууллагын Удирдлага Санхүүжилтийн тухай Хууль (ТБУСХ).....	17
2.1.1 ТБУСХ-ийн тухай товч ойлголт .....	17
2.1.2 Бүсчилсэн хөгжилд нөлөө үзүүлэхүйц ТБУСХ-ийн заалтууд .....	18
2.1.3 ТБУСХ болон БХУЗХ хоорондын уялдаа.....	23
2.2 Нийгэм Эдийн Засгийн Хөгжлийн Үндсэн Чиглэл: 2004 .....	24
2.3 Дунд хугацааны төсвийн хүрээ (ДХТХ).....	
2.4 Бүс Нутгийн Хөгжлийг Дэмжих Үндэсний Хорооны Дүрэм.....	26
2.5 Бүсийн Зөвлөлийн Ажиллах Журам.....	26
<b>3. Бусад асуудлууд .....</b>	<b>27</b>
3.1 Бүсчлэлийн зорилго.....	27
Хавсралт 1.....	29
Хавсралт 2.....	35

## ӨМНӨХ ҮГ

Энэ нь МУ-ын БНХ-ийн бодлого, төлөвлөлтийн тодорхой асуудлыг авч үзэж байгаа цуврал баримт бичгийн долдугаарх нь юм. “Бүс нутгийн хөгжлийн нэгдсэн төлөвлөлтийн чадавхийг бүрдүүлэх нь” МОН 3948 ТТ-ны хүрээнд хийгдсэн ажлын явцад анхаарал татсан сэдвүүдийг сонгон авсан болно. Зарим сэдвүүд нь төрийн албан хаагчдын дэвшүүлж байсан асуудал, хүсэлттэй холбоотой.

Эдгээр баримт бичгүүд нь товч бөгөөд ЗГ, олон улсын хөгжлийн байгууллага зэрэг холбогдох бусад талуудад бодлогын хэлэлцүүлгийн асуудлаар мэдээлэл өгөх, түүнчлэн ЗГ, төрийн байгууллагын БНХ-ийн бодлогын чадавхийг бэхжүүлэхэд тус дэм болох юм. Баримт бичигт хэлэлцсэн асуудлаар онцлог зөвлөмжүүдийг боловсруулж тусгасан болно.

Монгол улс болон түүний ард түмний цэвэр эрх ашгийн төлөө мөн үү? Өөрөөр хэлбэл хэлэлцэж буй асуудлаар дэвшүүлсэн санал, стратеги нь нийгэм/эдийн засгийн үр ашигтай юу? гэсэн зарчмын асуултад бүх баримт бичгүүд тулгуурласан болно. Түүнчлэн хэлэлцэж буй зарим асуудлыг шийдвэрлэх илүү үр дүнтэй өөр арга зам байна уу? гэдгийг мөн харгалзан үзсэн юм.

## БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖИЙН БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

Но. 1: Бүс нутгийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулах “үйл явц”-д тулгуурлах арга зам. 2003 он, 12 сар (англи, монгол).

Но. 2: Бүс нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн онол, тодорхойлолтууд. 2003 он, 12 сар (англи, монгол).

Но. 3: Монголын бүс нутгийн хөгжлийн үзүүлэлтүүд ба индексүүд, 2004 оны 1 сар (англи, монгол).

Но. 4: Функциональ бүс нутгуудыг тодорхойлох нь, 2004 оны 2 сар (англи, монгол).

№. 5: Тулгуур төвүүд, үйлдвэр, аж ахуйн газрын кластер ба бүс нутгийн хөгжил (англи, монгол).

№. 6: Бүс нутгийн хөгжил: Зах зээлийн эдийн засаг дахь засгийн газрын үүрэг 2004 он 3-р сар (англи, монгол)

№. 7: Бүсчилсэн хөгжлийн удирдлага, төлөвлөлтийн бүтэц зохион байгуулалт 2004 оны 4 сар (англи, монгол)

## БҮС НУТГИЙН БОДЛОГО

Бүс нутгийн бодлого нь:

- 1 Тухайн улс орны бүс нутгууд, ялангуяа нийслэл хот, түүнээс алслагдсан бүс нутгууд хоорондын тэнцвэрт бус байдлыг багасгах арга хэмжээ юм.
- 2 Онц хүндрэлтэй нөхцөлд байгаа хот, хотхон, бусад харьцангуй жижиг суурин газруудад ЗГ-аас үзүүлэх тусламж дэмжлэг юм. (Роутледж Эдийн засгийн толь бичиг, 2002)

## **БАРИМТ БИЧГЭЭС ГАРАХ ҮНДСЭН ЗӨВЛӨМЖҮҮД**

Засгийн Газрын тухай хуулийн 34-р зүйлд заасныг үндэслэн Ерөнхий сайдын дэргэдэх Эдийн Засгийн Стратеги Төлөвлөлтийн Албыг аль болох хурдан байгуулахыг **зөвлөмж болгож байна.**

БХУЗХ болон Засгийн Газрын 2004 оны 1-р сарын 30-ны өдрийн 27-р тогтоолд заасныг үндэслэн бүс нутгийн хөгжлийн үйл ажиллагааг зохицуулах, Үндэсний Хороонд мэргэжлийн дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий Ажлын албыг Эдийн Засгийн Стратеги Төлөвлөлтийн Албад байршуулахыг **зөвлөмж болгож байна.**

СЭЗЯ-ны Эдийн засгийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газарт харъяалдаг бүс нутгийн хөгжлийн асуудал хариуцсан нэгжийг Эдийн Засгийн Стратеги Төлөвлөлтийн Албад шилжүүлэхийг **зөвлөмж болгож байна.**

Үндэсний Хороо болон Бүсийн Зөвлөлийн гишүүнчлэлд хувийн хэвшил, ТББ болон бусад оролцоот байгууллагуудыг хамруулахыг **зөвлөмж болгож байна.**

Нийгэм эдийн засгийн хөгжлийн үндсэн чиглэл болон дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг бэлтгэх явцад Үндэсний Хороо болон түүний Ажлын алба, Бүсийн Зөвлөлүүд ямар байдлаар оролцож байхыг нарийвчлан тодорхойлж Нийгэм эдийн засгийн хөгжлийн үндсэн чиглэл болон дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг бэлтгэх журамд тусгаж өгөхийг **зөвлөмж болгож байна.**

“Салбарын бүсүүд”-ийг бий болгож голлох салбар яамдын эрх мэдлийн нягтралыг сааруулах асуудлыг дэмжиж, үүнийг бодит байдалд хэрэгжүүлэх замаар бүсчилсэн хөгжлийн бодлогын хэрэгжилтийг дэмжихийг **зөвлөмж болгож байна.**

# 1. БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН УДИРДАГА, ТӨЛӨВЛӨЛТИЙН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

## 1.1 ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Дараахи хуулиуд нь бүсчилсэн хөгжлийн удирдлага, төлөвлөлтийн бүтэц зохион байгуулалтын үндэс суурь болж байна. Үүнд: (1) Монгол Улсын Үндсэн хууль; (2) Засгийн Газрын тухай хууль; (3) Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль; (4) Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль (БХУЗХ).

Бүсчилсэн хөгжлийн төлөвлөлтийн бүтэц зохион байгуулалтад Бүсчилсэн Хөгжлийн Үзэл Баримтлал чиглүүлэх үүргийг, харин бүс нутгийн бодлогыг хэрэгжүүлэхэд Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль (ТБУСХ), Төсвийн хүрээний дунд хугацааны мэдэгдэл, Жил бүрийн нийгэм эдийн засгийн үндсэн чиглэл зэрэг нь чухал үүргийг гүйцэтгэж байна.

## 1.2 БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН УДИРДАГЫН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Монгол улс нь удирдлагын 4 шатлалтай зохион байгуулалтын бүтэцтэй:

- Засгийн газар;
- Нийслэл хот, аймгийн Засаг даргын тамгын газрууд (21 аймаг);
- Сумд, нийслэл хотын дүүргүүдийн Засаг даргын тамгын газрууд (340 сум, нийслэл хотын 9 дүүрэг);
- Баг, хороод (1671 баг, 121 хороо).

2001 онд УИХ-аар батлагдсан Бүсчилсэн Хөгжлийн Үзэл Баримтлалаар эдийн засгийн 5 бүсийг тодорхойлсон.


Дараа нь 2003 онд бүсүүдийг хөгжүүлэх арга хэмжээг өргөнөөр агуулсан Бүсүүдийн Хөгжлийн Дунд Хугацааны Стратегийг боловсруулж баталсан.

2003 онд батлагдсан БХУЗХ нь бүсчилсэн хөгжлийн удирдлагын эрх зүйн үндсэн зарчмыг тодорхойлсон. Энэ хуульд бүсчилсэн хөгжлийг дэмжих орон тооны бус Үндэсний Хороо болон таван Бүсийн Зөвлөлийг

байгуулахаар заасан. Бүсийн зөвлөлүүд нь засаг захиргааны нэгж биш бөгөөд бүс нутгийн хөгжлийг дэмжих талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, бүсийн нийгэм эдийн засгийн асуудлыг зохицуулах чиг үүрэг бүхий байгууллага байна.

1-р зурагт бүсчилсэн хөгжлийн удирдлагын бүтэц зохион байгуулалтыг харууллаа. Эндээс байгууллагуудын үндсэн чиг үүрэг, хоорондын уялдаа холбоог харж болно. Эдгээр байгууллагуудын бүсчилсэн хөгжлийн талаар хүлээсэн эрх, үүрэг, хариуцлагын талаар энэ баримт бичгийн 1.4-р хэсэгт тодорхой бичсэн.

**Зураг 1: Бүсчилсэн Хөгжлийн Удирдлагын Бүтэц Зохион Байгуулалт  
(БХУЗБХ-д зааснаар)**



Улсын Их Хурал, Засгийн газар болон Үндэсний Хороо нь бүсчилсэн хөгжлийн удирдлагын тогтолцоог үндэсний хэмжээнд бүрдүүлж байна. Харин аймаг болон нийслэл хотын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлууд, Засаг Даргын Тамгын Газрууд, Бүсийн Зөвлөлүүд нь ийм тогтолцоог бүсийн түвшинд бүрдүүлж байна.



Засгийн газар болон орон нутгийн Засаг Даргын Тамгын газрууд нь бүс нутгийн хөгжлийн бодлогын хэрэгжилтийг удирдан явуулна. Харин Үндэсний Хороо болон Бүсийн Зөвлөлүүд нь бүс нутгийн хөгжлийн үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулах үүргийг хүлээж байна.

### **1.3 БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

Засгийн газрын тухай хуульд зааснаар СЭЗЯ нь бүс нутгийн хөгжлийн асуудлыг хариуцдаг. Энэ асуудлыг хариуцсан жижиг нэгж (2 ажилтантай) СЭЗЯ-ны Эдийн Засгийн Нэгдсэн Бодлого Төлөвлөлтийн Газарт (ЭЗНБТГ) байршдаг.

Одоогоор Монгол улсын Засгийн газар нь бүс нутгийн хөгжлийн төлөвлөлтийн асуудлыг бие даан хариуцсан байгууллагыг (бусад орнуудад байдаг Бүс нутгийн хөгжлийн агентлаг зэрэг байгууллагуудтай ижилсэх) байгуулах шаардлагагүй гэж үзэж байгаа ба бүс нутгийн хөгжлийн төлөвлөлтийг үндэсний хөгжлийн төлөвлөлттэй нэгтгэн гаргаж байх хандлагыг баримталж байна. Ингэснээрээ бүс нутгийн хөгжлийн бодлого, стратегийг үндэсний хөгжлийн асуудалтай уялдуулж өгч байгаа юм. Өнөөгийн байдлаар энэхүү арга барил нь хамгийн зохимжтой гэдгийг дараахи нөхцөл байдал нотолж байна:

**Бүс нутгийн хөгжлийн төлөвлөгөөний онцлог шинж чанар.** Хэд хэдэн бүсийг амжилттай хөгжүүлэх замаар үндэсний бодлогын гол зорилтууддаа хүрэх боломж нилээд олон тохиолдолд байдаг<sup>1</sup>. Бүс нутгийн хөгжлийн бодлого нь Монгол орныг тэр чигт нь хамарч байгаа болохоор бүс нутгийн хөгжлийн асуудлууд үндэсний төлөвлөгөөнд ихээхэн байр суурь эзэлнэ гэдэг нь ойлгомжтой юм.

**Өнөөгийн үндэсний төлөвлөлтийн бүтэцэд гарч байгаа хүндрэлүүд.** Бүсчилсэн хөгжлийн удирдлага, төлөвлөлтийн бүтэц зохион байгуулалтад нөлөөлөхүйц хоёр төрлийн хүндрэл байна:

1. *Тохиромжгүй бүтэц зохион байгуулалт.* Одоогоор СЭЗЯ нь санхүү, эдийн засгийн бодлогыг хариуцдаг. СЭЗЯ-ны ЭЗНБТГ нь нийгэм эдийн засгийн

---

<sup>1</sup> Улсын хөрөнгө оруулалт ба бүс нутгийн эдийн засгийн хөгжил, Даниел Фелсенстейн, 2001  
Бодлогын зөвлөмжийн баримт бичиг №7: Бүсчилсэн хөгжлийн удирдлага, төлөвлөлтийн бүтэц зохион  
байгуулалт

хөгжлийн бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулах ажлыг хариуцсан гол газар юм. СЭЗЯ нь бусад яамдын хамт хэвтээ тогтолцоонд ижил статустай байдаг, ЭЗНБТГ ч мөн СЭЗЯ-ны бусад газруудтай ижил статустай байдаг. Энэ байдал нь СЭЗЯ-ны бусад яамдын бодлого, төлөвлөлт, хөтөлбөр боловсруулах үйл ажиллагааг хянаж, зохицуулах талаар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд нь хүндрэл учруулж байна<sup>2</sup>. Мөн ЭЗНБТГ-ын хувьд зөв бодлого боловсруулж түүнийгээ хэрэгжүүлэх, хэрэгжилтийг нь хянах үүргээ гүйцэтгэхэд нь саад бэрхшээл учруулж байна. Жишээ нь, үндэсний төлөвлөгөөг боловсруулах аргачлал нь тодорхой бодлого, стратегийн зорилгод тулгуурлагдахаасаа илүү Засгийн газрын үйл ажиллагааны 2001-2004 оны хөтөлбөрт тусгасан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд хязгаарлагдмал нөөцөө хэрхэн хуваарилахыг шийдвэрлэхэд чиглэгдэж байна.

2. *Бодлого хөтөлбөрүүдийн уялдаагүй байдал.* Одоогоор Монгол оронд бусад бодлого, хөтөлбөрүүдийг чиглүүлж өгөх урт удаан хугацааны үндэсний хөгжлийн бодлого алга. Уялдаа муутай боловсруулсан бодлого, хөтөлбөрүүд нь үндэсний төлөвлөлтийн ажлыг илүү төвөгтэй болгож байна.

Ийм нөхцөлд бүс нутгийн хөгжлийн асуудал хариуцсан тусгай байгууллагыг үүсгэн байгуулах эсхүл бүс нутгийн хөгжлийн төлөвлөгөөг тусад нь боловсруулах явдал нь зохицуулалтын ажиллагааг улам нэмэгдүүлж магадгүй. Түүнчлэн бүс нутгийн хөгжлийн төлөвлөлтөд тусгагдсан арга хэмжээнүүд нь өөр бусад төлөвлөгөөнүүдэд тусгагдан давхардал үүсгэх магадлалтай юм.

Бүсчилсэн хөгжлийн төлөвлөлтийн бүтэц зохион байгуулалтын хүрээнд байгууллагуудын хүлээсэн тодорхой үүрэг хариуцлагуудыг БХУЗХ-иар заасан. Энэ хуульд зааснаар СЭЗЯ нь Бүсийн Зөвлөлүүдтэй хамтран тухайн бүсийг хөгжүүлэх зорилт, авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж, Эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, дунд хугацааны хөтөлбөрт тусгуулах арга хэмжээг авах үүрэгтэй. Салбар яамд нь салбарын хөгжлийн үндсэн чиглэл, хөтөлбөр, төслүүдээ боловсруулж, хэрэгжүүлэх үүргийг хүлээсэн. Ингэхдээ өөрсдийн бодлого, хөтөлбөр, төслүүдээ бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулж байх ёстой. ТБУСХ-иар салбар яамдад бодлого боловсруулах, хөтөлбөр зохиох, төлөвлөх илүү эрх мэдлийг

---

<sup>2</sup> ТБУСХ-ийн дагуу салбар яамд төсөвлөлтийн ихээхэн хэмжээний эрх мэдэлтэй болсноор энэ байдал илүү гүнзгийрсэн.

олгосноор тэдэнд бүсчилсэн хөгжлийн бодлого болон БХУЗХ-тай өөрийн үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулах илүү уян хатан байдлыг олгож байгаа юм.

Саяхан гарч ирсэн дунд хугацааны төсвийн хүрээний аргачлал нь үндэсний төлөвлөлтийн бүтцийн голлох хэсэг болж байна. Дунд хугацааны төсвийн хүрээний аргачлал нь бодлого, төлөвлөлт, төсөвлөлтийг нэгдмэл хүрээнд авч үздэг. Дэлхийн Банкнаас дүгнэн хэлснээр нэгдсэн бодлого, төлөвлөлт, төсөвлөлттэй байна гэдэг нь бодлогын тэргүүлэх чиглэлээр жолоодуулж, төсвийн бодит байдалд захирагдсан зарлагын хөтөлбөртэй байхтай ерөнхийдөө ижил юм<sup>3</sup>.

Бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги нь ихээхэн хэмжээний хөтөлбөр, төслүүдийг агуулж байгаагийн хувьд бүс нутгийн хөгжлийн төлөвлөлт нь дунд хугацааны төсвийн хүрээнээс ихээхэн хамааралтай байна. Энэ талаар энэхүү баримт бичгийн 2.1 хэсэгт тодорхой яригдана.

Бүс нутгийн хөгжлийн төлөвлөлт нь үндэсний төлөвлөлтийн хүрээнд хийгдэх учраас үндэсний төлөвлөлтийн бүтцийг сайжруулах нь бүс нутгийн хөгжилд ихээхэн нөлөөлтэй байх болно. Өөр нэг чухал зүйл бол бүс нутгийн бодлого, БХУЗХ-ийг бүрэн хэрэгжүүлэх бүтэц зохион байгуулалтыг бий болгох асуудал юм. СЭЗЯ нь бүс нутгийн хөгжлийн асуудлыг хариуцна гэж Засгийн газрын тухай хуулиар заасан байдаг. Гэтэл хэрэгжилтийн шатан дээр гарч ирэх зохицуулалт, хяналт, үнэлгээтэй холбоотой ажлууд нь Үндэсний Хороо, Бүсийн Зөвлөлүүдийн эрх үүрэгт хамаарч байна. Дээр хэлсэнчлэн, СЭЗЯ-ийн өнөөгийн статус нь үндэсний бодлого, төлөвлөлт, түүний дотор, бүс нутгийн хөгжлийн төлөвлөлтөд хамаарах үйл ажиллагаануудыг үр ашигтай удирдан зохион байгуулах боломжийг олгож чадахгүй байна. Өнөөдрийн байдлаар үндэсний эдийн засгийн бодлого, төлөвлөлтийн асуудлыг хариуцсан тохирох эрх мэдэл бүхий бие даасан байгууллагыг бий болгох шаардлага гарч ирээд байна.

Иймээс:

- ➔ Засгийн Газрын тухай хуулийн 34-р зүйлд заасныг үндэслэн Ерөнхий сайдын дэргэдэх Эдийн Засгийн Стратеги Төлөвлөлтийн Албыг аль болох хурдан байгуулахыг **зөвлөмж болгож байна.**

<sup>3</sup> Төсвийн зарлагын удирдлагын тухай гарын авлага, ДВ, 1998

- ➔ БХУЗХ болон Засгийн Газрын 2004 оны 1-р сарын 30-ны өдрийн 27-р тогтоолд заасныг үндэслэн бүс нутгийн хөгжлийн үйл ажиллагааг зохицуулах, Үндэсний Хороонд мэргэжлийн дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий Ажлын албыг Эдийн Засгийн Стратеги Төлөвлөлтийн Албад байршуулахыг **зөвлөмж болгож байна.**
- ➔ СЭЗЯ-ны ЭЗНБТГ-т байршдаг бүс нутгийн хөгжлийн асуудлыг хариуцсан нэгжийг шинээр байгуулагдах алба руу шилжүүлэхийг **зөвлөмж болгож байна.**

## 1.4 ГОЛ БАЙГУУЛЛАГУУДЫН ЭРХ МЭДЭЛ, ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

### 1.4.1 УИХ

Монгол улсын Үндсэн хуульд зааснаар хууль тогтоох эрхийг зөвхөн УИХ-д олгосон. Бүсчилсэн хөгжилтэй холбогдуулан хүлээх УИХ-ын эрх мэдэл, үүрэг хариуцлагыг БХУЗХ-д дараахи байдлаар заасан:

- Бүсчилсэн хөгжлийн эрх зүйн зохицуулалтыг бий болгох,
- Эдийн засгийн бүсчлэлийн ерөнхий бүдүүвч, бүсийн тулгуур төвүүдийг тогтоох
- Бүсүүдийн хөгжлийн стратегийг хэлэлцэж батлах
- Тодорхой бүс нутагт зам тээвэр, эрчим хүч, холбоо, мэдээллийн үндсэн тэнхлэгийн сүлжээг байгуулах бодлогыг тодорхойлох
- Бүсийн хөгжлийн асуудлаар байгуулсан олон улсын гэрээ хэлэлцээрийг соёрхон батлах.

### 1.4.2 Засгийн Газар

Монгол улсын Үндсэн хууль болон Засгийн газрын тухай хуулиар Монгол улсын Засгийн газарт бүс нутгийн хөгжлийн бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх эрхийг олгосон. Бүсчилсэн хөгжилтэй холбогдуулан хүлээх Засгийн газрын эрх мэдэл, үүрэг хариуцлагыг мөн БХУЗХ-иар заасан:

- бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын талаар төрөөс баримтлах бодлого хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах,

- бүсийн хөгжлийн хөтөлбөрийг батлах, стратегийг УИХ-д өргөн мэдүүлэх,
- орон нутгийн хөгжлийн төвүүдийг тогтоох,
- бүсийн хөгжлийн тулгуур төвүүдийн хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг батлах,
- бүсийн хөгжлийн талаархи төрийн зохицуулга, татвар, зээл, хөрөнгө оруулалттай холбоотой асуудлуудаар санал дэвшүүлж УИХ-д өргөн мэдүүлэх,
- салбар яамд, Бүсийн Зөвлөлүүд хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах,
- бүсийн хөгжлийн талаархи олон улсын гэрээ, хэлэлцээр байгуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих,
- бүс нутгийн хөгжилд дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих,
- дэд бүтцийн зам тэнхлэгийг барьж байгуулах ажлыг бүс нутгийн бодлогод нийцүүлэх

### 1.4.3 Үндэсний Хороо

Үндэсний Хороо нь бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын үйл ажиллагааг зохицуулах, бүсчилсэн хөгжлийн талаархи Засгийн Газрын ерөнхий стратегийг тодорхойлох чиг үүрэгтэй. Үндэсний Хорооны эрх мэдэл, үүрэг хариуцлагын талаар илүү дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 1-ээс үзнэ үү.

### 1.4.4 Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газар

БХУЗХ-иар Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газарт (ЗГХЭГ) холбогдуулан бүс нутгийн хөгжлийн асуудалд хамаарах эрх мэдэл, үүрэг хариуцлагыг тодорхойлон заагаагүй. Гэхдээ ЗГХЭГ нь дор дурьдсан хууль тогтоомжийн заалтуудын дагуу бүсчилсэн хөгжлийн удирдлага, төлөвлөлтийн бүтэц зохион байгуулалтад чухал үүрэг гүйцэтгэх ёстой. Эдгээр хууль тогтоомж нь:

- Засгийн газрын тухай хуультийн 33-р зүйлд зааснаар ЗГХЭГ нь Засгийн газрын шийдвэр боловсруулах, хэрэгжүүлэх, төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын харилцан ажиллагааг зохицуулахад туслах асуудлыг эрхлэн гүйцэтгэнэ.
- 1996 оны УИХ-ын 38-р тогтоолын дагуу ЗГХЭГ нь Ерөнхий сайд, Засгийн газрын Танхимын тэргүүлэн манлайлах чиг үүргийг дэмжих

байгууллага мөн бөгөөд үндэсний хэмжээнд тэргүүлэн манлайлах, стратегийн удирдамжаар хангах ерөнхий чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь 1/ бодлогын үндсэн чиглэлийг тогтоох, 2/ бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, 3/ нөөцийн удирдлагаар хангах, 4/ гүйцэтгэх удирдлагаар хангах үйл ажиллагааны хүрээнд дэмжин туслах үүрэгтэй.

#### **1.4.5 Санхүү Эдийн Засгийн Яам (СЭЗЯ)**

Засгийн газрын тухай хуулийн 4-р бүлгийн 20-р зүйлд зааснаар СЭЗЯ нь бүс нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлт, удирдлага, зохицуулалт, хэрэгжилт, дүн шинжилгээ, хяналтын асуудлуудыг хариуцна.

БХУЗХ-ийн 14-р зүйлд СЭЗЯ-ны бүсчилсэн хөгжлийн талаархи эрх мэдлийг нарийвчлан зааж өгсөн. Үүнд:

- Бүсчилсэн хөгжлийн стратегийг боловсруулах,
- Бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан аймаг нийслэлийн болон сумын хөтөлбөр боловсруулахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх,
- Үндэсний Хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх мэргэжлийн зөвлөгөөгөөр хангах

#### **1.4.6 Салбар Яамд**

БХУЗХ-д зааснаар салбар яамд нь бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан салбарын хөгжлийн үндсэн чиглэл, хөтөлбөр төслийг боловсруулж хэрэгжүүлэх, салбарын бүсчлэлийг тогтоох, дэд бүтцийн хөгжил, байршлын бүдүүвчийг тогтоох, салбарын хүрээний асуудлаар Зөвлөлүүдийн ажлыг уялдуулах, мэргэжлийн зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах эрх үүрэгтэй.

Салбар яамд нь ТБУСХ-ийн дагуу бүс нутгийн хөгжлийн олон үйл ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлэх болно. Харин Аймгийн засаг дарга нар нь өөрсдийн бүтээгдэхүүнээ гэрээний дагуу салбар яамдад нийлүүлнэ.

#### **1.4.7 Бүсийн Зөвлөлүүд**

БХУЗХ-д зааснаар Бүсийн Зөвлөлүүд нь бүс нутгийн хөгжлийг дэмжих талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, бүсийн нийгэм эдийн засгийн асуудлыг зохицуулах чиг үүрэгтэй. Мөн СЭЗЯ-тай хамтран тухайн бүсийг хөгжүүлэх зорилт, авч хэрэгжүүлэх арга

хэмжээг тодорхойлж Эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, дунд хугацааны хөтөлбөрт тусгуулах арга хэмжээг авах үүрэгтэй.

#### **1.4.8 Нийслэл Хот, Аймгуудын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлууд**

БХУЗХ-ийн дагуу нийслэл хот, аймгийн ИТХ-ууд нь дараахи эрхийг эдэлнэ:

- Бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан нутаг дэвсгэрийнхээ хөгжлийн байдал, хэтийн төлөвийн асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх,
- Бүс нутгийн хөгжлийн асуудлаар Засаг даргын тайланг хэлэлцэх,
- Тухайн бүсэд хамаарах бусад ИТХ-тай хамтран ажиллах,
- Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын хамтын оролцоог дэмжин чиглүүлэх

#### **1.4.9 Нийслэл Хот, Аймгуудын Засаг Дарга нар**

Аймгуудын Засаг дарга нар бүс нутгийн хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулах ёстой. ТБУСХ-д зааснаар аймгийн засаг дарга нар нь өөрсдийн бүтээгдэхүүнээ гэрээний дагуу салбар яамдад нийлүүлнэ. Эдгээр бүтээгдэхүүний ихэнх нь бүс нутгийг хөгжүүлэхэд хамааралтай.

БХУЗХ-иар нийслэл хот, аймгуудын Засаг дарга нарт бүсчилсэн хөгжлийн асуудлаар тодорхой эрх мэдлийг олгосон. Үүнд:

- Тухайн бүсийг хөгжүүлэх талаар Бүсийн Зөвлөлөөс гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх,
- Бүсийн Зөвлөлийн үйл ажиллагаанд бүх талын дэмжлэг үзүүлэх,
- БНХ-ийн талаар хийж байгаа ажлаа Бүсийн Зөвлөлд тайлагнах.

### **1.5 БҮС НУТГИЙН ХӨГЖЛИЙН АСУУДАЛД ХУВИЙН ХЭВШИЛ БОЛОН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДЫН ОРОЛЦОО**

БХУЗХ-иар хувийн хэвшил болон ТББ-ын оролцоог тохирох хэмжээнд тодорхойлж өгч чадаагүй. Ихэнх орнуудын туршлагаас харахад Үндэсний Хороо болон Бүсийн Зөвлөлүүдтэй ижил төстэй байгууллагуудын бүтэц нь хувийн хэвшил, ТББ болон бусад оролцогчдыг өргөн хүрээтэй хамарсан байх юм.

Хувийн хэвшил нь бүс нутгийн хөгжилд ихээхэн хэмжээний үр нөлөөг авчирдаг. Монгол улсын дотоодын нийт бүтээгдэхүүнд хувийн хэвшил 70-аас илүү хувийг эзэлж байна. Иймээс томоохон компаниуд болон жижиг дунд үйлдвэрийн аль аль нь монгол орны аль ч газар нутагт эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлж, ажлын байрыг бий болгоход чухал үүрэг гүйцэтгэх нь ойлгомжтой. ТББ-д нь ч Монгол улсын хөгжилд ялангуяа бүс нутгийн хөгжлийн асуудалд ихээхэн үүргийг гүйцэтгэнэ. Иймд хувийн хэвшил нь бүсчилсэн хөгжлийн үйл ажиллагаанд, ялангуяа Үндэсний Хороо болон Бүсийн Зөвлөлүүд нь бүсчилсэн хөгжлийн төлөвлөлт, зохицуулгатай холбогдуулан хүлээсэн үүргээ биелүүлэх шатанд Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим зэрэг бусад ТББ-аар дамжуулан оролцох ёстой.

Иймээс:

- ➔ Үндэсний Хороо болон Бүсийн Зөвлөлүүдийн гишүүнчлэлийг хувийн хэвшил, ТББ болон бусад оролцогчдоор өргөжүүлэхийг **зөвлөмж болгож байна.**

“бүсчилсэн хөгжлийн хамтын ажиллагаа” нь Зураг 2,3-г үзүүлсэн байдлаар явагдах нь тохиромжтой байж болох юм.



## Зураг 2: Үндэсний түвшин дэх хамтын ажиллагаа



## Зураг 3: Бүсийн түвшин дэх хамтын ажиллагаа



## 1.6 ҮНДЭСНИЙ ХОРООНЫ АЖЛЫН АЛБАНЫ БАЙРШИЛ

БХУЗХ-ийн 6.5-р зүйлд “Үндэсний Хороо нь Ажлын албатай байна. Ажлын албаны үүргийг Ерөнхий сайдын дэргэдэх эдийн засгийн стратеги, төлөвлөлтийн алба хэрэгжүүлнэ” гэж заасан. Одоогоор ерөнхий сайдын дэргэд ийм алба байхгүй. 2004 оны 1-р сард СЭЗЯ нь Үндэсний Хорооны Ажлын албыг СЭЗЯ дээр “Бүсчилсэн хөгжлийн бодлого зохицуулалтын газар” нэртэйгээр байгуулахаар Засгийн Газарт дор дурьдсан үндэслэлүүдийн хамт санал оруулсан:

- Ерөнхий сайдын дэргэдэх эдийн засгийн стратеги, төлөвлөлтийн алба нь одоогоор байгуулагдаагүй байгаа,
- СЭЗЯ нь бүс нутгийн хөгжлийн бодлого, зохицуулалтын асуудлыг хариуцдаг,
- Санхүү эдийн засгийн Сайд нь Үндэсний Хорооны орлогч дарга учраас СЭЗЯ болон Үндэсний Хороо хоорондын үйл ажиллагааг үр ашигтайгаар зохицуулах боломжтой,
- БХУЗХ-д зааснаар Ажлын алба нь бие даасан удирдлагын нэгж байхыг шаардсан.

Ажлын албаны байршлын асуудлаас гадна энэ нэгжийн үүрэг даалгавраа гүйцэтгэх чадавхийг тодорхой хэмжээгээр бэхжүүлэх шаардлага бас гарч ирж байна. Одоогийн байгаа чадавхи сул байгаа ба, ажилтны тоог нэмэгдүүлэх, ялангуяа зах зээлийн эдийн засагтай уялдсан бүс нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн чиглэлээр сургалтад хамрагдсан, микро эдийн засгийн бодлогоор мэргэшсэн ажилтнуудаар өргөжүүлэх нь чухал байна.

СЭЗЯ-аас гарсан санал болон одоогийн байгаа бүтэц зохион байгуулалтыг харахад ажлын давхардал үүсэх, бүс нутгийн хөгжлийн үйл ажиллагааны зохицуулга сулрах талууд гарч ирж болзошгүй байна.


СЭЗЯ-аас гаргасан Ажлын албаны бие даасан байдалтай холбоотой 4 дэх үндэслэлийг харахад, энэхүү үндэслэл нь харин СЭЗЯ дээр байршуулахын эсрэг үндэслэл болгон ашиглагдаж болох юм. Ажлын албаны байршлын талаар дараахи үндэслэлүүдийг нэмж харгалзан үзэж болох юм:

- Яамд, агентлагууд, Бүсийн Зөвлөлүүдийн үйл ажиллагааг зохицуулах зорилготой, Ерөнхий сайдаар толгойлуулсан Үндэсний Хороог дэмжих үүрэгтэй байхаар Ажлын албыг тодорхойлсон байна. Мөн бүс нутгийн хөгжлийн стратегийг хэрэгжүүлэхэд хөрөнгө оруулагчид, иргэд,

байгууллагуудын хоорондын хамтын ажиллагааг дэмжих, зохицуулах үүрэгтэй байхаар заажээ. Ингэхээр Ажлын албыг СЭЗЯ дотор байршуулсан тохиолдолд Ажлын албаны эрх мэдэл нь буурч Үндэсний Хороонд үзүүлэх үйлчилгээ, хүлээсэн үүргээ биелүүлэх боломж нь буурч болзошгүй юм.

- Үндэсний хороо нь яамдын сайд нар, төрийн нарийн бичгийн дарга нар болон ЗГХЭГ-ын даргыг өөртөө хамруулж байгаа нь Ажлын албыг яамны бүтцээс гадуур байршуулах шаардлагыг бий болгож байна.

Иймээс:

 Ерөнхий сайдын дэргэд Эдийн Засгийн Стратеги Төлөвлөлтийн Газрыг аль болох хурдан байгуулж тэндээ Үндэсний Хорооны Ажлын албыг БХУЗХ-д заасны дагуу байршуулахыг **зөвлөмж болгож байна.**

## **2. БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН УДИРДЛАГА, ТӨЛӨВЛӨЛТИЙН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТАД ХАМААРАХ ХҮРЭЭ**

### **2.1 ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГА САНХҮҮЖИЛ- ТИЙН ТУХАЙ ХУУЛЬ (ТБУСХ)**

#### **2.1.1 ТБУСХ-ийн тухай товч ойлголт**

Монгол улсын засгийн газар 1997 оноос эхлэн төсвийн байгууллагын удирдлагын шинэчлэлийн Шинэ Зеландын загварыг сонирхож эхэлсэн. Шинэ Зеландын загварыг удирдлагын ил тод байдлыг дээшлүүлэх, төсөвлөлтийн явц дахь санхүүгийн менежментийг сайжруулах арга зам мөн гэж тодорхойлж байсан.

Шинэ Зеландын загварыг нэвтрүүлэх зорилгоор 2002 онд УИХ-аас баталсан ТБУСХ нь төсвийн байгууллагуудын удирдлага, санхүүжилтийн шинэчлэлийн эрх зүйн үндсийг бий болгосон. Уг хуулиар боловсон хүчний удирдлага, гарцад суурилсан төсөвлөлт, стратегийн бизнес төлөвлөгөө (үндэсний болон салбарын түвшинд), улсын зарлагын хяналт, ерөнхий менежерийн эрх мэдэл ба хариуцлага зэрэг шинэчлэлийн бүрэлдэхүүн хэсгүүдийг танилцуулсан<sup>4</sup>.

Төсвийн байгууллагын шинэчлэлийг хийх хэд хэдэн шалтгаан байсан. Үүнд:

- Зарлагын ангилал хангалтгүй байсан
- Засгийн газрын агентлагуудын мэдэлд, шууд хяналт хийх боломжгүй олон төрлийн бие даасан сангууд байсан
- Хяналтын сул байдал: СЭЗЯ-аас зарлагыг хянах боломж маш бага байсан
- Нэгдсэн төсвийн сахилга батыг чангатгахад хүндрэл учирсаар байсан
- Хөндлөнгийн аудит хийх чадавхи байгаагүй

1990-2000 онуудад орон нутгийн төсвийн алдагдал ихээхэн хэмжээгээр нэмэгдсэн. Энэ нь төсвийн зарлагын хяналтыг дээшлүүлж санхүүгийн эх үүсвэрийг үр ашигтай зарцуулахыг шаардаж байсан (Хүснэгт 1).

---

<sup>4</sup> Төсвийн зарлагын удирдлагын үйл ажиллагааны гарын авлага 2001, СЭЗЯ

## 2.1.2 Бүсчилсэн хөгжилд нөлөө үзүүлэхүйц ТБУСХ-ийн заалтууд

Дунд Хугацааны Бүсүүдийн Хөгжлийн Стратегид тусгасан саналуудын ихэнх хэсэг нь төсвийн орлого (олон төрлийн татвар, орлого нэмэгдүүлэх хөшүүрэг) болон зарлагад (тухайн бүсэд бодит болон нийгмийн дэд бүтцийг бий болгоход чиглэсэн захиргааны болон хөгжлийн нэмэлт зардлууд) ихээхэн хамаарлыг үүсгэж байна<sup>5</sup>.

Иймээс бүс нутгийн хөгжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ төсвийн бүтэц, өөрөөр хэлбэл ТБУСХ-ийн шаардлагуудыг авч үзэх шаардлага гарч ирж байна. Энэ шаардлагаас үүдэн ТБУСХ-ийн бүс нутгийн хөгжилд үзүүлэх зарим нөлөөллүүдийг энэхүү хэсэгт авч үзэв.

### Төв засгийн газрын түвшинд үзүүлэх нөлөөлөл

ТБУСХ-ийн хамгийн чухал хэсэг бол Дунд хугацааны төсвийн хүрээний аргачлал юм. Энэхүү аргачлал нь менежментийг сайжруулж санхүүгийн эх үүсвэрийг зохистой байршуулах замаар стратегийн зорилтууддаа хүрэх замыг хялбарчилж өгч байгаа юм. 2002 оноос эхлэн СЭЗЯ нь жил бүрийн 3-р сарын 31 гэхэд улс орны төсвийн зорилт, стратегийг товч бөгөөд утга төгөлдөр тодорхойлсон дунд хугацааны төсвийн хүрээг (ДХТХ) бэлтгэж байх үүргийг хүлээсэн.

ДХТХ дээр үндэслэн СЭЗЯ нь 6-р сарын 30 гэхэд бүх яам агентлагуудын ирэх төсвийн жилийн “дээрээс доош чиглэсэн” төсвийн дээд хязгаарыг (Зураг-4) тогтооно. Бүх яамд, агентлагууд дээрээс өгсөн хязгаар дээр үндэслэн 3 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрөө бэлтгэх ба хэрэгжүүлэх хөтөлбөр, үйл ажиллагааны өртөг, зардлын урьдчилсан тооцоог “доороос дээш” өгөх шаардлагатай (Зураг-4). Ямар ч байсан яамд, агентлагууд нь дээрээс өгсөн төсвийн дээд хязгаарын хүрээнд өөрсдийн үйл ажиллагааг ангилж, өртгийг нь тооцох үүргийг хүлээсэн.


ЗГ-ын БНХ-ийн бодлого нь үндэсний цар хүрээтэй, олон яамд, салбаруудыг хамарч байгаагийн хувьд одоогийн ДХТХ-д түүний эзлэж байгаа байр суурь нь засгийн газрын түвшинд сонирхол татаж байна. Үүнээс гадна БХДХС-т тусгагдсан ихэнх арга хэмжээ нь төсвийн орлого болон зарлагын аль альд нь

<sup>5</sup> Бүс нутгийн хөгжлийг дэмжих эдийн засгийн хүрээ 2003, Жим Ламонт, АХБ ТА-3948

### ХҮСНЭГТ 1: Орон нутгийн төсвийн орлогын зарлагад эзлэх хувь (оны үнээр)

Аймаг, нийслэл хот	1 990			1 995			1 999			2 000		
	Орлого	Зарлага	Хувь	Орлого	Зарлага	Хувь	Орлого	Зарлага	Хувь	Орлого	Зарлага	Хувь
Архангай	71,0	127,8	56%	359,8	1 761,6	20%	594,3	3 260,6	18%	1 183,7	4 555,0	26%
Баян-Өлгий	111,5	137,2	81%	460,2	1 817,8	25%	887,4	3 345,5	27%	719,3	4 237,1	17%
Баянхонгор	73,1	129,3	57%	506,6	1 779,7	28%	642,3	3 225,5	20%	894,5	4 770,2	19%
Булган	53,9	108,1	50%	963,5	1 526,6	63%	1 066,8	3 121,8	34%	1 170,4	4 026,6	29%
Говь-Алтай	68,6	122,3	56%	376,7	1 580,3	24%	581,2	3 195,4	18%	584,7	4 045,1	14%
Дорноговь	67,4	107,0	63%	322,5	1 208,6	27%	1 173,6	2 796,6	42%	1 436,9	3 709,6	39%
Дорнод	142,0	119,2	119%	804,9	1 579,5	51%	878,8	3 244,2	27%	1 128,2	4 301,5	26%
Дундговь	50,2	105,5	48%	262,5	1 185,8	22%	549,7	2 083,8	26%	673,1	2 830,4	24%
Завхан	76,7	167,6	46%	506,8	2 002,6	25%	801,6	3 913,8	20%	906,2	4 887,6	19%
Өвөрхангай	98,4	128,9	76%	892,2	1 855,0	48%	1 369,8	3 654,3	37%	1 329,6	4 691,1	28%
Өмнөговь	54,4	115,5	47%	322,6	1 187,9	27%	682,8	2 455,8	28%	794,3	3 248,2	24%
Сүхбаатар	41,8	91,5	46%	412,4	1 629,0	25%	468,7	2 892,4	16%	521,4	3 838,4	14%
Сэлэнгэ	101,8	131,1	78%	2 503,1	2 899,6	86%	4 554,3	4 656,9	98%	4 379,1	7 668,8	57%
Төв	124,1	146,9	84%	1 757,7	2 174,0	81%	2 463,1	4 233,7	58%	3 863,3	6 462,0	60%
Увс	77,4	131,8	59%	488,4	1 961,8	25%	726,8	3 194,4	23%	931,0	4 809,1	19%
Ховд	58,3	131,2	44%	392,0	1 789,9	22%	709,1	3 243,3	22%	883,9	4 548,5	19%
Хөвсгөл	103,4	144,0	72%	739,1	2 393,6	31%	1 034,7	4 109,5	25%	1 169,7	5 578,2	21%
Хэнтий	72,8	109,8	66%	618,9	1 792,1	35%	897,1	3 270,4	27%	1 122,2	4 686,8	24%
Дархан-Уул	243,5	155,3	157%	1 527,0	1 783,3	86%	4 093,5	4 935,4	83%	3 170,3	5 946,4	53%
Улаанбаатар	970,2	898,2	108%	15 326,8	17 529,8	87%	31 084,3	32 389,0	96%	36 145,5	41 633,6	87%
Орхон	163,0	57,5	283%	1 364,2	1 487,4	92%	3 311,1	3 283,0	101%	4 059,1	5 142,9	79%
Говьсүмбэр				423,5	486,6	87%	278,0	761,5	37%	445,8	1 079,2	41%
<b>НИЙТ</b>	<b>2 823,5</b>	<b>3 365,7</b>	<b>84%</b>	<b>31 331,4</b>	<b>53 412,5</b>	<b>59%</b>	<b>58 849,0</b>	<b>101 266,8</b>	<b>58%</b>	<b>67 512,2</b>	<b>136 696,3</b>	<b>49%</b>

Зураг 4: БХУЗХ ба ДХТХ хоорондын уялдаа



хамаарал үүсгэж байна. Иймээс дунд хугацааны төсвийн хүрээний “саравчин” дор эдгээр арга хэмжээнүүдийг санхүүжүүлэхийн тулд өрсөлдөх шаардлага гарч ирж байна<sup>6</sup>.

Иймээс бүс нутгийн хөгжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ төсвийн бүтэц, өөрөөр хэлбэл ТБУСХ-ийн шаардлагуудыг авч үзэх шаардлага гарч ирж байна. Энэ шаардлагаас үүдэн ТБУСХ-ийн бүс нутгийн хөгжилд үзүүлэх зарим нөлөөллүүдийг энэхүү хэсэгт авч үзэв.

### **Төв засгийн газрын түвшинд үзүүлэх нөлөөлөл**

ТБУСХ-ийн хамгийн чухал хэсэг бол Дунд хугацааны төсвийн хүрээний аргачлал юм. Энэхүү аргачлал нь менежментийг сайжруулж санхүүгийн эх үүсвэрийг зохистой байршуулах замаар стратегийн зорилтууддаа хүрэх замыг хялбарчилж өгч байгаа юм. 2002 оноос эхлэн СЭЗЯ нь жил бүрийн 3-р сарын 31 гэхэд улс орны төсвийн зорилт, стратегийг товч бөгөөд утга төгөлдөр тодорхойлсон дунд хугацааны төсвийн хүрээг (ДХТХ) бэлтгэж байх үүргийг хүлээсэн.

ДХТХ дээр үндэслэн СЭЗЯ нь 6-р сарын 30 гэхэд бүх яам агентлагуудын ирэх төсвийн жилийн “дээрээс доош чиглэсэн” төсвийн дээд хязгаарыг (Зураг-4) тогтооно. Бүх яамд, агентлагууд дээрээс өгсөн хязгаар дээр үндэслэн 3 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрөө бэлтгэх ба хэрэгжүүлэх хөтөлбөр, үйл ажиллагааны өртөг, зардлын урьдчилсан тооцоог “доороос дээш” өгөх шаардлагатай (Зураг-4). Ямар ч байсан яамд, агентлагууд нь дээрээс өгсөн төсвийн дээд хязгаарын хүрээнд өөрсдийн үйл ажиллагааг ангилж, өртгийг нь тооцох үүргийг хүлээсэн.

ЗГ-ын БНХ-ийн бодлого нь үндэсний цар хүрээтэй, олон яамд, салбаруудыг хамарч байгаагийн хувьд одоогийн ДХТХ-д түүний эзлэж байгаа байр суурь нь засгийн газрын түвшинд сонирхол татаж байна. Үүнээс гадна БХДХС-т тусгагдсан ихэнх арга хэмжээ нь төсвийн орлого болон зарлагын аль альд нь хамаарал үүсгэж байна. Иймээс дунд хугацааны төсвийн хүрээнд эдгээр арга хэмжээнүүдийг тусгуулахын тулд өрсөлдөх шаардлага гарч ирж байна<sup>7</sup>.

<sup>6</sup> Үүс нутгийн хөгжлийг дэмжих эдийн засгийн хүрээ 2003, Жим Ламонт, АХБ ТА-3948

<sup>7</sup> Үүс нутгийн хөгжлийг дэмжих эдийн засгийн хүрээ 2003, Жим Ламонт, АХБ ТА-3948



ТБУСХ гарч ирэхээс өмнө СЭЗЯ нь нэгдсэн төсвийн удирдлага, зарлагын хяналтын үйл ажиллагааг явуулах үүргийг хүлээж байсан. Иймээс СЭЗЯ нь салбар яамд болон орон нутгийн засаг захиргаанаас хөрөнгө оруулалтын болон урсгал зардлын саналуудыг хүлээн авч, хянаж, тэргүүлэх чиглэлийг тогтоох, төсвийг хуваарилах үүргийг гүйцэтгэж ирсэн. Харин ТБУСХ гарч ирснээр санхүүгийн удирдлагын зарим хариуцлагыг салбар яамдад шилжүүлэн өгсөн. Энэ байдал нь салбар яамдыг өөрийн хөтөлбөрөө бие даан боловсруулах, үйл ажиллагааныхаа тэргүүлэх чиглэлийг тогтоох чадавхи бүхий төлөвлөлтийн бүтэцтэй байхыг шаардаж байна. Харин энэ үүргээ дээрээс тогтоосон төсвийн дээд хязгаарын хүрээнд гүйцэтгэнэ.

Хөтөлбөр боловсруулах, үйл ажиллагааныхаа тэргүүлэх чиглэлийг тогтоох, төлөвлөх тал дээр салбар яамд илүү бие даасан байдалтай болсон нь тэдэнд салбарын бодлого, хөтөлбөрүүдээ амжилттай хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлж өгч байна. Салбар яамд нь өөрсдөө бүсийн түвшин дэх засаг захиргаагаар дамжуулан бүсчилсэн удирдлагын хүрээнд салбарын хөгжлийн үйл ажиллагаагаа явуулах нь хамгийн тохиромжтой арга гэдгийг олон орны туршлага харуулсаар ирлээ. Харин ТБУСХ нь энэ аргыг хэрэгжүүлэхэд хамгийн таатай нөхцлийг бүрдүүлэн өгч байгаа юм.

### **Орон нутгийн засаг захиргааны түвшинд үзүүлэх нөлөөлөл**

ТУСТХ-ийн дагуу орон нутгийн үйл ажиллагааны санхүүжилтийн механизмд өөрчлөлт хийсэн нь орон нутгийн түвшинд гарсан томоохон өөрчлөлт юм. Уг хуулийн дагуу орон нутгийн засаг дарга нар нь зөвхөн орон нутгийн тохижилтын чанартай үйл ажиллагаанд төсөв зөрцуулах эрх мэдэлтэй үлдсэн. Засаг дарга нар нь үндэсний ач холбогдол бүхий бусад үйлчилгээг (эрүүл мэнд, боловсрол гэх мэт) засгийн газарт гарцад суурилсан гэрээний дагуу нийлүүлж байхаар болсон. Өөрөөр хэлбэл төв засгийн газар нь орон нутгийн засаг захиргаанаас үйлчилгээг “худалдан” авч байх хэлбэрт шилжсэн.

Гэхдээ орон нутгийн Засаг дарга нарт 3 жилийн үйл ажиллагааны хөтөлбөр, стратеги бизнес төлөвлөгөөгөө боловсруулж, төсвийн саналаа бэлдэх ажлыг удирдан зохион байгуулах, орон нутгийн төсвийн байгууллагуудын үйл ажиллагааг удирдах, ерөнхий менежерийг нь сонгох, томилох, гарцын нийлүүлэлт болон санхүүгийн гүйцэтгэлийг хянах эрхийг олгосон. Хэдийгээр орон нутгийн Засаг дарга нар нь төсвийн удирдлагын уян хатан байдлаа тодорхой хэмжээнд алдсан ч гэсэн үндэсний хөгжлийн

бодлого, тэр дундаа бүс нутгийн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд гүйцэтгэх үүрэг хариуцлага нь хэвээр үлдсэн.

ТБУСХ нь орон нутгийн байгууллагуудад өөрсдийн бүтэц зохион байгуулалтаа тодорхойлох, ингэснээрээ засаг захиргааны зардлаа хэмнэх, гарсан хэмнэлтээрээ хөгжлийн үйл ажиллагааны санг байгуулах уян хатан эрхийг олгосон.

ТБУСХ-ийн нэг чухал зүйл бол орон нутгийн болон төв засгийн газрын түвшинд хариуцлагыг өндөржүүлж төсвийн байгууллага хоорондын санхүүгийн харилцааны ил тод байдлыг дээшлүүлсэн.

### 2.1.3 БХУЗХ болон ДХТХ хоорондын уялдаа

ДХТХ нь бүхий л төсвийн байгууллагуудыг жилийн урьдчилсан төсөв болон стратеги бизнесийн төлөвлөгөө бэлдэхийг шаарддаг. Бодит болон нийгмийн дэд бүтцийг тухайн бүсэд сайжруулах саналууд бүгд л бүс нутгийн хөгжлийн бодлоготой уялдан стратеги бизнес төлөвлөгөөнд тусгагдсан байх шаардлагатай.

ДХТХ-г бэлдэх явцад Бүсийн Зөвлөлүүд бүсүүдийн хөгжлийн тэргүүлэх ач хобогдол бүхий арга хэмжээнүүдийг ДХТХ болон жил бүрийн нийгэм эдийн засгийн үндсэн чиглэлд тусгуулахын тулд яамд, агентлагуудтай нягт хамтран ажиллах шаардлагатай. Орон нутгийн засаг захиргаа ч мөн энэ талаар нилээд зүтгэл гаргах хэрэгтэй болно. Иймд Бүсийн зөвлөлүүд, орон нутгийн засаг дарга нар нь яамд, агентлагууд, ялангуяа СЭЗЯ, тус яамны газруудтай ямар байдлаар хамтран ажиллаж байхыг маш тодорхой болгох нь зүйтэй.

Үндэсний Хороо болон түүний Ажлын алба нь Засгийн газар ДХТХ-г хянан хэлэлцэх, мөн төсөв батлах явцад (Зураг-4) нилээд чухал үүрэг гүйцэтгэх шаардлагатай. Ажлын алба нь бүс нутгийн бодлого, стратегид дүн шинжилгээ хийх, ДХТХ-г эдгээр бодлого, стратегитай яаж уялдуулж болох талаар мэргэжлийн зөвөлгөө өгөх үүргийг гүйцэтгэх байх.

Иймээс:

- ➔ Үндэсний Хороо болон түүний Ажлын алба, Бүсийн Зөвлөлүүд нь ДХТХ болон нийгэм эдийн засгийн хөгжлийн үндсэн чиглэлийг бэлтгэх явцад ямар байдлаар оролцож байхыг нарийвлан тодруулж

ДХТХ болон нийгэм эдийн засгийн хөгжлийн үндсэн чиглэлийг бэлтгэх журамд тусгаж өгөхийг зөвлөмж болгож байна.

## **2.2 2004 ОНЫ НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ**

Нийгэм эдийн засгийн үндсэн чиглэлд тухайн жилд авч хэрэгжүүлэх бодлогын зорилтууд, тухайн бодлогын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд, шаардагдах хугацаа, хариуцах эзэн зэргийг нэгтгэн тусгадаг. 2004 оны Нийгэм эдийн засгийн үндсэн чиглэлд макро эдийн засгийн хүрээнд авч хэрэгжүүлэх, бүс нутгийн хөгжилд чухал ач холбогдол бүхий хэд хэдэн зорилтуудыг тусгасан байна. Үүнд:

- Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийг 2004 онд 6,0 хувьд хүргэнэ.
- Инфляцийг макро эдийн засгийн тогтворжилтийг бататгах, микро түвшинд үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлэх, бизнесийн тогтвортой орчинг бүрдүүлэх, хөрөнгө оруулалтыг урамшуулах түвшинд байлгана.
- Зах зээлийн зарчимд нийцсэн мөнгөний бодлогыг явуулах замаар эдийн засгийн өсөлтийг дэмжинэ.
- Эдийн засгийг 2021 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөгжлийн хөтөлбөрийг боловсруулна.

Үндсэн чиглэлд бүс нутаг болон хөдөөгийн хөгжлийн бодлоготой холбогдуулан хэд хэдэн арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр заасан. Үүнд: (i) бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратегийг хэрэгжүүлэх төлөвлөлт, зохион байгуулалтын үндсийг бүрдүүлэх; (ii) бүсийн тулгуур төв хотуудын эдийн засгийн чадавхийг үнэлж, цаашид нэмэгдүүлэх нөхцлийг бүрдүүлж эхлэх; (iii) Монгол улсад чөлөөт бүс байгуулах ажлыг эрчимжүүлэх.

Бүсчилсэн хөгжлийн бүтэц зохион байгуулалтад нөлөөлөхүйц зарим нэг арга хэмжээг нийгэм эдийн засгийн үндсэн чиглэлд тусгасан байна. Үүнд:

- БХУЗХ- д нийцүүлэн Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хууль, Хот байгуулалтын тухай хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулж тэдгээрийг уялдаатай хэрэгжүүлэх эрх зүйн нэгдмэл орчинг бүрдүүлнэ;

- Бүсийн Зөвлөлүүдийн Ажиллах журмыг батална.

### **2.3 ДУНД ХУГАЦААНЫ ТөСВИЙН ХҮРЭЭ: 2004-2006**

Улсын төсвийн дунд хугацааны хүрээг боловсруулахдаа 2001-2004 онд Засгийн Газраас хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц байдал, Ядуурлыг бууруулах, өсөлтийг хангах хөтөлбөрөөр ОУВС-тай тохиролцсон хүчин зүйлс болон дунд хугацааны зорилтуудыг агуулсан бусад баримт бичгүүд дээр үндэслэжээ.

Монголын Засгийн газар нь 2004-2006 оны ДХТХ-д тэргүүлэх ач холбогдол бүхий бодлогын зорилтуудаа тодорхойлсон. Эдгээр зорилтуудаас зарим нэг нь бүс нутгийн хөгжилд ач холбогдолтой. Үүнд:

- Банк бус санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих замаар санхүүгийн зах зээлд шударга өрсөлдөөнийг бий болгож, хөдөө орон нутагт мөнгөний урсгалыг нэмэгдүүлэх,
- Мөнгөний бодлогоор эдийн засгийн өсөлтийг дэмжиж Төв банкны үнэт цаасны хүүг бууруулах замаар жижиг дунд үйлдвэрийг дэмжих, хөгжүүлэх боломжийг нэмэгдүүлэх,
- ДНБ-ний өсөлтийг 2004-2006 онд 5.3-5.5 хувиас доошгүй түвшинд хүргэнэ
- Аж ахуйн нэгж, байгууллагуудын орлогын албан татварын дээд шатлалыг 28 хувь болгон бууруулах.

2004-2006 оны ДХТХ-д бүсчилсэн хөгжилтэй холбоотой цөөн тооны зорилтыг тусгасан байна:

- Эдийн засгийн хөгжлийн стратегийг бүс нутгаар төлөвлөх тогтолцоонд аажмаар шилжих
- Алсагдсан хөдөө нутаг, ялангуяа говь нутгийн хүмүүсийн ажлын тогтвортой байдлыг хангах, тэдний чадавхийг дээшлүүлэх,
- Дунд хугацаанд төлөвлөсөн сургуулийн барилгуудын ихэнхийг бүсийн тулгуур төвүүдэд барина.

## **2.4 БҮС НУТГИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДҮРЭМ, АЖИЛЛАХ ЖУРАМ**

Монгол улсын Засгийн газар 2004 оны 1-р сард бүс нутгийн хөгжлийг дэмжих Үндэсний Хорооны журмыг баталсан. Уг журмаар Үндэсний Хорооны удирдлага, зохион байгуулалт, ажиллах журмыг тодорхойлсон.

Үндэсний Хорооны үндсэн зорилго нь бүсчилсэн хөгжлийн талаар баримтлах засгийн газрын ерөнхий стратегийг тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэхэд төрийн захиргааны бүх шатны байгууллага, аймаг, нийслэл, Бүсийн Зөвлөлүүдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, бүс нутгийг хөгжүүлэх талаар дотоод, гадаадын хөрөнгө оруулагч байгууллага, иргэдийн хамтын ажиллагааг дэмжин зохион байгуулахад оршно гэжээ. Үндэсний хорооны эрх мэдэл, үүрэг хариуцлага, үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг энэхүү баримт бичгийн Хавсралт 1-ээс үзэж болно.

## **2.5 БҮСИЙН ЗӨВЛӨЛҮҮДИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ**

БХУЗХ-д зааснаар Бүсийн Зөвлөлүүд нь бүс нутгийн хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, бүсийн нийгэм эдийн засгийн асуудлыг зохицуулах үүрэгтэй. Бүсийн зөвлөлийн ажиллах журмын талаар нарийн мэдээллийг Хавсралт 2-оос үзнэ үү.

## 3. БУСАД АСУУДАЛ

### 3.1 БҮСЧЛЭЛИЙН ЗОРИЛГО

Монгол улс 5 бүсийн загварыг авч хэрэгжүүлэхээр болоод байна. Эдгээр 5 бүсийг тогтоохдоо одоогийн байгаа дэд бүтэц, аж үйлдвэржилтийн байдал, зах зээлийн хүчин зүйлс болох эрэлт нийлүүлэлтийн харьцаан дээр үндэслэхээс илүү захиргаадлын арга барилыг түлхүү хэрэглэжээ<sup>8</sup>.

Энэхүү 5 бүсийн загвар нь Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тодорхойлсны дагуу эдийн засгийн загвар байхаасаа илүү засаг захиргааны загвар байдлаар авч хэрэгжүүлвэл илүү үр ашгаа өгч чадах юм. Засаг захиргааны 5 бүсийг хүлээн зөвшөөрч баталсан тохиолдолд Монгол орны засаг захиргааны бүтцийг илүү оновчтой, үр ашигтайгаар өөрчлөх боломжийг олгоно. Монгол орон одоогоор 2000 илүү засаг захиргааны нэгжтэй. Эдгээр нэгжүүдийн ихэнх нь үр ашиггүй үйл ажиллагаагаа явуулж байна. Асар олон тооны засаг захиргааны нэгж оршин тогтносноор алслагдмал хөдөө нутагт хүн амын зохиомол төвлөрлийг бий болгож, Монгол орны хүн амын хязгаарлагдмал нөөцийг бутлан тараах нөхцлийг бүрдүүлж байна. Энэ байдал нь орон нутгийн болон үндэсний эдийн засагт дараахи байдлаар сөргөөр нөлөөлж байна. Үүнд: (i) Бие биенээсээ алслагдсан жижиг зах зээлүүдийг бий болгож байна. Эдгээр зах зээлүүдийн эрэлтийн түвшин хэт доогуур ба ихэнхдээ амьдралын наад захын хэрэгцээний барааны нийлүүлэлтэд хязгаарлагдаж байна, (ii) Алслагдмал байдал, хэт тархсан хүн ам, засаг захиргааны олон тооны жижиг нэгж зэрэг хүчин зүйлс нь улсын үйлчилгээний өртгийг нилээд хэмжээгээр нэмэгдүүлж байна.

Засаг захиргааны нэгжийг оновчтой өөрчилснөөр тодорхой хэмжээний үр ашгийг авчирна. Үүнд: (i) улсын зардлыг хэмнэх, (ii) өргөжилт явагдсанаар үр өгөөж нэмэгдэж улсын үйлчилгээний чанар дээшлэх; (iii) томоохон засаг захиргааны нэгжүүд нь хүн амын төвлөрлийг нэмэгдүүлнэ. Ингэснээр зах зээлийн багтаамж ихэсч, бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээний төрөлжилт болон өрсөлдөөн нэмэгдэх илүү таатай нөхцлийг бүрдүүлнэ.

---

<sup>8</sup> АХБ ТТ3948-МОН, Бодлогын зөвлөмжийн баримт бичиг №4

Мэдээжээр засаг захиргааны өөрчлөлтийг богино хугацаанд хийх боломжгүй. Энэ нь олон талын сөрөг үр дагаварыг авчрах магадлалтай. Гэхдээ урт хугацааны бодлого, стратегийн зорилт дээр тулгуурлан аажим аажмаар өөрчлөлтийг хийх нь зохистой.

Засаг захиргааны бүс нь эдийн засгийн бүстэй давхцаж байвал илүү сайн. Гэхдээ дээр дурьдсанчлан 5 бүсийн загвар нь засаг захиргааны бүс байх нь илүү зохимжтой ба эдгээр бүсүүдэд эдийн засгийн эрүүл бүтэц байх нөхцөл хараахан бүрдэж чадаагүй байна. Мөн дээр дурьдсанчлан эдийн засгийн бүс нь зах зээлийн хүчин зүйлс болох эрэлт нийлүүлэлтийн харьцаагаар, одоогийн байгаа дэд бүтэц, аж үйлдвэржилтийн байдал дээр тулгуурлан гарч ирэх ёстой.

Эдийн засгийн бүсүүд нь салбарын бодлого дээр үндэслэгдэн тодорхойлогдож, зохион байгуулагдаж болох юм. Салбарын хөгжлийн үйл ажиллагаа нь бүсчилсэн удирдлагын хүрээнд явагдсанаар илүү амжилтад хүрч байгааг олон улсын туршлага харуулсаар байна. Өнөөгийн хууль эрх зүйн хүрээ, ялангуяа ТБУСХ, ДХТХ-ний аргачлал, БХУЗХ зэрэг нь салбар яамдад өөрсдийн салбарын удирдлагын оновчтой бүтцийг бий болгох таатай нөхцлийг бүрдүүлж өгч байна.

Иймээс:



“салбарын бүсүүд”-ийг бий болгож голлох салбар яамдын эрх мэдлийн нягтралыг сааруулах асуудлыг дэмжиж, үүнийг бодит байдалд хэрэгжүүлэх замаар бүсчилсэн хөгжлийн бодлогын хэрэгжилтийг дэмжихийг **зөвлөмж болгож байна.**

# Хавсралт 1: Үндэсний хорооны дүрэм, ажиллах журам

## Монгол Улсын Засгийн Газрын Тогтоол № 27

2004 оны 1-р сарын 30  
Улаанбаатар хот

Үндэсний Хорооны дүрэм, ажиллах журам батлах тухай

Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль /БХУЗХ/-ийн  
6.1, 6.6-г үндэслэн Монгол улсын Засгийн газраас тогтоох нь:

1. Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, бүсчилсэн хөгжлийн асуудлаар Засгийн газрын ерөнхий стратегийг тодорхойлох чиг үүрэг бүхий орон тооны бус Үндэсний хорооны дүрмийг хавсралт ёсоор баталсугай.
2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Үндэсний хороо үйл ажиллагаа явуулахад шаардагдах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд даалгасугай.

Монгол улсын Ерөнхий сайд

Н.Энхбаяр

Санхүү, эдийн засгийн сайд

Ч.Улаан



Засгийн газрын 2004 оны 27-р тогтоолын хавсралт

## ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДҮРЭМ, АЖИЛЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

Үндэсний хороо /цаашид “Хороо” гэх/ -ны үндсэн зорилго нь бүсчилсэн хөгжлийн талаар баримтлах Засгийн газрын ерөнхий стратегийг тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэхэд төрийн захиргааны бүх шатны байгууллага, аймаг, нийслэл, Бүсийн зөвлөлүүдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, бүс нутгийг хөгжүүлэх талаар дотоод, гадаадын хөрөнгө оруулагч байгууллага, иргэдийн хамтын ажиллагааг дэмжин зохион байгуулахад оршино.

Хороо нь үйл ажиллагаандаа БХУЗХ болон бусад хууль тогтоомж, энэхүү дүрмийг удирдлага болгоно.

Хорооны үйл ажиллагааны зардалыг Хороо хуралдаанаараа хэлэлцэн батлах бөгөөд эх үүсвэрийг нь жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлнэ.

Хороо нь тогтоосон журмын дагуу үйлдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

### Хоёр. Хорооны удирдлага, зохион байгуулалт

БХУЗХ-ийн 6-р зүйлд заасны дагуу Хороог байгуулна.

Хорооны дарга дараахи бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

Хороог төлөөлөх,

Хорооны хуралдааныг товлон хэлэлцэх асуудлыг тогтоож, Хорооны хуралдааныг даргалах,

Хорооны хүлээсэн үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон шийдвэр гаргах,

Хорооны гишүүдийг томилох, чөлөөлөх,

Хорооны гишүүдэд үүрэг даалгавар өгч биелэлтэд нь хяналт тавих,

Хорооны ажлын албаны даргыг томилох,

Хууль тогтоомжинд заасан болон шаардлагатай гэж үзсэн Хорооны хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг Засгийн газар УИХ-д оруулж шийдвэрлэх, танилцуулах.

Хорооны даргын эзгүйд түүний бүрэн эрхийг Хорооны орлогч дарга хэрэгжүүлнэ.

Хорооны гишүүд нь хариуцсан салбарын хүрээн дэх бүсчилсэн хөгжлийн асуудлыг зохицуулж ажлын үр дүнг Хороонд тайлагнана.

Хороо нь бүсчилсэн хөгжлийн тулгамдсан асуудлаар, холбогдох мэргэжлийн хүмүүс, эрдэмтэд, судлаачдыг оролцуулсан ажлын хэсэг, төслийг баг ажиллуулж, дүгнэлт гаргуулж болно.

### **Гурав. Хорооны ажиллах журам**

3.1 Хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна.

3.2 Хорооны хуралдаанаар дараахи асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ,

3.2.1 Бүсчилсэн хөгжлийн талаар баримтлах Засгийн газрын ерөнхий стратегийн төсөл, бүс нутгийн болон тухайн бүс дэх салбарын хөгжлийн хөтөлбөр, төслүүд,

3.2.2 Бүсчилсэн хөгжлийн төсөл, арга хэмжээг улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, улсын төсөв, дунд хугацааны хөгжлийн хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх санал, үндэслэл,

3.2.3 Бүс нутгийн хөгжлийг хөрөнгө оруулалт, татвар, зээлийн бодлогоор дэмжих санал,

3.2.4 Бүс нутгийн хөгжлийг дэмжих сан байгуулах, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, зарцуулах, хяналт тавих журмын хэрэгжилтийн явц, байдал,

3.2.5 Бүсийн хэлэлцээр байгуулах журмын төсөл боловсруулж түүнийг хэрэгжүүлэх санал, үндэслэл,

3.2.6 Чөлөөт бүс, аж үйлдвэрийн паркийн хөгжлийн бодлого, зохицуулалтын асуудалд өгөх санал, дүгнэлт,

- 3.2.7 Нийслэлийн болон бүсийн тулгуур төвүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хөгжлийн төсөв, тэдгээрийн хэрэгжилтийн явц, байдлын талаар санал боловсруулах,
  - 3.2.8 Бүсүүдэд олон улсын байгууллага, гадаад орны зээл тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний үр дүн, тэдгээрийг уялдуулан зохицуулах санал, дүгнэлт,
  - 3.2.9 Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд орон нутгийн иргэдийн саналыг үндэслэн, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох санал үндэслэлийг Үндэсний хороо хэлэлцэж, засгийн газарт оруулна,
  - 3.2.10 Бүсчилсэн хөгжлийн улсын нэгдсэн бодлогын хүрээнд яам, газар, аймаг, нийслэл хот болон бүсийн зөвлөлүүдийн хоорондын ажлын уялдаа зохицуулалтыг хангах, санал дүгнэлт,
  - 3.2.11 Бүсийн зөвлөлүүдэд хуулиар тогтоосны дагуу гүйцэтгэх засаглалын байгууллагын зарим эрх хэмжээг шилжүүлэх санал,
  - 3.2.12 Бүсийн зөвлөлүүдийн жил, хагас жилийн ажлын тайлан, үр дүнгийн талаархи мэдээлэл, санал, тэдгээрийн үйл ажиллагаанд Хорооны ажлын албанаас өгсөн үнэлэлт дүгнэлт,
  - 3.2.13 Хорооны ажлын албаны эрх, үүргийг тогтоож, жил, хагас жилд гүйцэтгэсэн ажлын тайланг хэлэлцэх,
  - 3.2.14 Хорооноос байгуулсан ажлын хэсэг, төслийн багийн гүйцэтгэсэн ажлын тайлан, үнэлгээ санал,
- 3.3 Хороо нь хорооны хуралдааны дэгийг баталж шийдвэрийн биелэлтэд нь тухайн асуудлыг хариуцсан Хорооны гишүүд тус тусын хяналт тавьж ажиллах бөгөөд Хорооны ажил хэргийн гүйцэтгэлийн ерөнхий хяналтыг Хорооны орлогч дарга, Хорооны гишүүн – ЗГХЭГ-ын дарга нар хэрэгжүүлнэ.
- 3.4 Хуралдааны шийдвэр тогтоол, хэлбэртэй байх бөгөөд, хуралдааны явцад тэмдэглэл хөтөлнө.
- 3.5 Хорооны тогтоол, Хорооны дарга тухайн асуудал хариуцсан Хорооны гишүүн хуралдааны тэмдэглэлд, Хорооны орлогч дарга, түүний эзгүйд Хорооны ажлын албаны дарга гарын үсэг зурж баталгаажуулна.
- 3.6 Хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг хуралд оролцсон гишүүдийн ердийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Санал тэнцсэн буюу эсхүл зөрсөн тохиолдолд асуудлыг хуралдаан даргалагчийн саналаар шийдвэрлэнэ.

3.7 Хороо нь улиралд нэгээс доошгүй удаа хуралдана. Шаардлагатай үед Хорооны дарга ээлжит бус хуралдааныг зарлан хуралдуулж болно.

3.8 Хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг Хорооны ажлын алба бэлтгэх бөгөөд хүлээн авч хянаж, хуралд оруулах саналаа Хорооны дарга, орлогч дарга нарт танилцуулна.

3.9 Хорооны даргаас зөвшөөрсний дагуу ажлын алба хурлаар хэлэлцэх асуудлын танилцуулга, холбогдох бусад материалыг хурал эхлэхээс ажлын 3 өдрийн өмнө Хорооны гишүүдэд тараасан байна.

3.10 Хорооны хуралдаанд холбогдох албан тушаалтнаас гадна шаардлагатай бол, аж ахуйн нэгж болон ТББ-ын төлөөлөгчийг байлцуулж тэдний санал дүгнэлтийг сонсож болно.

### **Дөрөв. Хорооны ажлын алба**

4.1 Хорооны ажлын албаны үүргийг бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухайн хуулийн 6.5-д заасны дагуу Монгол улсын Ерөнхий сайдын дэргэдэх эдийн засгийн стратеги төлөвлөлтийн алба хэрэгжүүлнэ.

4.2 Хорооны ажлын албаны орон тоо, зохион байгуулалтын бүтэц, ажиллах эрх, үүргийг Хороо хуралдаанаараа хэлэлцэж тогтооно.

4.3 Ажлын албаны дарга нь ажлаа Хороонд улирал тутам, Хорооны орлогч даргад тухай бүр тайлагнаж ажиллана.

4.4 Ажлын Алба нь Хорооны албан бичгийн хэвлэмэл хуудсыг хэрэглэж болно.

# Хавсралт 1: Бүсийн зөвлөлүүдийн ажиллах журам

## Монгол Улсын Засгийн Газрын Тогтоол № 28

2004 оны 1-р сарын 30  
Улаанбаатар хот

Бүсийн зөвлөлийн ажиллах журмыг батлах тухай

Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль /БХУЗХ/ -ийн 10.7-г үндэслэн Монгол улсын Засгийн газраас тогтоох нь:

1. Бүсийн зөвлөлийн ажиллаж журмыг хавсралт ёсоор баталсугай.
2. Бүсийн зөвлөлийн үйл ажиллагааг явуулахад шаардагдах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авахыг Санүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд даалгасугай.
3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Аймаг, Дархан, Эрдэнэт хотын засаг захиргааны байгууллагуудыг бэхжүүлэх арга хэмжээний тухай” БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1990 оны 4-р сарын 14-ний өдрийн 162-р тогтоол, “Гадаад худалдааны үйл ажиллганы талаар авах зарим арга хэмжээний тухай” БНМАУ-ын Засгийн газрын 1991 оны 11-р сарын 22-ний өдрийн 316-р тогтоол, “Худалдааны байгууллагын зохион байгуулалтыг зах зээлийн тогтолцоонд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай” БНМАУ-ын Загийн газрын 11-р сарын 22-ны өдрийн 317-р тогтоолын тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Монгол улсын Ерөнхий сайд

Н.Энхбаяр

Санхүү, эдийн засгийн сайд

Ч.Улаан

Засгийн газрын 2004 оны 28-р тогтоолын хавсралт

## **БҮСИЙН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1 БХУЗХ-ийн 10-р зүйлд заасан Бүсийн зөвлөлийн /цаашид “Зөвлөл” гэх/ үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2 Зөвлөл нь үйл ажиллагаандаа БХУЗХ болон бусад хууль тогтоомж, энэхүү журмыг удирдлага болгоно.

1.3 Зөвлөлийн дарга, гишүүд нь бүсийн хүрээнд хуулиар өөрт нь олгогдсон бүрэн эрхээ бие даан хэрэгжүүлнэ.

1.4 Аж ахуйн нэгж, байгууллага болон ТББ-ын зөвлөлийн гишүүн төлөөлөгч нь Зөвлөлөөс өөрийн хүсэлтээр гарах эрхтэй. Уг асуудлыг Зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж энэ тухай Зөвлөлийн дарга бүс нутгийн хөгжлийг дэмжих Үндэсний хороо /цаашид “Үндэсний хороо” гэнэ/ -нд мэдэгдэнэ.

1.5 Зөвлөлийн гишүүн – аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөллийг Зөвлөлийн бүрэлдэхүүнд оруулах, гаргах асуудлыг тухайн шатны хурал өөрөө шийдвэрлэнэ.

1.6 Зөвлөлийн өдөр тутмын ажлыг Зөвлөлийн даргаар ажиллаж байгаа тухайн аймаг, нийслэлийн ЗДТГ хариуцан гүйцэтгэнэ.

### **Хоёр. Зөвлөлийн үйл ажиллагааны чиглэл**

2.1 Зөвлөл нь үйл ажиллагаагаа жилээр төлөвлөж, үр дүнг хагас, бүтэн жилээр Үндэсний хороонд тайлагнана.

2.2 Зөвлөл нь улиралд нэгээс доошгүй удаа хуралдах бөгөөд шаардлагатай үед Зөвлөлийн дарга эсхүл Засгийн газраас ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж болно.

2.3 Зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудал, хурлын товыг Зөвлөлийн хурлаас тогтооно. Хурлын бэлтгэл ажлыг Зөвлөлийн ажлын алба, уг асуудлыг хариуцсан Зөвлөлийн гишүүнтэй хамтран хангана.

2.4 Зөвлөлийн хурлаар дараахи асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.

- 2.4.1 Тухайн бүсийн хөгжлийн хөтөлбөр, төсөл, тэдгээрийн хэрэгжилтийн явц байдал,
- 2.4.2 Бүсийн хөгжлийн нийтлэг зорилтыг хэрэгжүүлэхэд аймгуудын оролцоо, уялдааг хангах асуудал,
- 2.4.3 Бүсийн хөгжлийг дэмжих санд хөрөнгө хуримтлуулах, түүнийг зарцуулах талаар Зөвлөлөөс гаргах шийдвэр,
- 2.4.4 Бүсийн хэлэлцээрээр зохицуулах асуудал, тэдгээрийн хэрэгжилтийн талаархи үнэлэлт, дүгнэлт
- 2.4.5 Бүсийн хөгжлийн асуудлыг зохицуулах талаар Засгийн газар, Үндэсний хороонд оруулах санал, мэдээлэл,
- 2.4.6 Аймаг нийслэлийн дотоод бүсчлэл, сум дундын бүсүүдийн хөгжлийг дэмжих зохицуулах асуудал,
- 2.4.7 Бүсийн хөгжлийн тулгуур төв хотуудын ерөнхий төлөвлөгөөний төсөл, тэдгээрийг хэрэгжүүлэхэд аймаг, салбар хоорондын уялдааг хангах асуудал,
- 2.4.8 Бусад Бүсийн зөвлөлтэй хамтран ажиллах асуудал,
- 2.4.9 Хөрш орнуудын хил зэргэлдээ бүс нутгуудтай харилцах асуудал,
- 2.4.10 Бүс нутгийн хөгжлийн асуудлаар аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс тавьсан санал хүсэлт,
- 2.4.11 Зөвлөлөөс байгуулсан ажлын хэсгийн дүгнэлт, Зөвлөлийн гишүүдийн ажлын тайлан, мэдээлэл,
- 2.4.12 Бусад

2.5 Зөвлөлийн хурлыг гишүүдийн олонхи оролцсон тохиолдолд хүчинтэйд тооцох бөгөөд хэлэлцсэн асуудлыг хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Цөөнхи болсон зөвлөлийн гишүүн үндэслэлээ тайлбарлаж дахин санал хураалгаж болно.

2.6 Зөвлөл нь бүсчилсэн хөгжлийн тодорхой асуудлаар холбогдох салбарын эрдэмтэд, мэргэжилтнүүдийг оролцуулсан ажлын хэсэг байгуулж судалгаа дүгнэлт гаргуулж болно.

2.7 Зөвлөлийн даргаар ажиллаж байгаа аймаг, нийслэлийн ЗДТГ нь судалгаа хийх санал, төсөл боловсруулах, зөвлөгөө өгөх, Зөвлөлд дэмжлэг үзүүлэх зэргээр ажиллана.

2.8 Зөвлөл нь шийдвэр гаргахдаа аль нэг талын болон орон нутгийн явцуу ашиг сонирхлын үүднээс хандахгүй байх зарчмыг баримтална.

2.9 Зөвлөлийн гишүүд нь хурлаас гарсан шийдвэрийнхээ төлөө хамтын хариуцлага хүлээх бөгөөд ажлын үр дүнгээ зөвлөлд тухай бүр тайлагнаж ажиллана.

2.10 Зөвлөлийн даргаар ажиллаж байгаа аймаг, нийслэлийн ЗДТГ нь Зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлын тухай танилцуулга, холбогдох материалыг бүрдүүлж, хурал болохоос 7 хоногийн өмнө гишүүдэд хүргүүлнэ.

2.11 Шаардлагатай гэж үзвэл Зөвлөлийн хуралд холбогдох хүмүүсийг байлцуулан, тэдний санал, дүгнэлтийг сонсож болно.

2.12 Зөвлөлийн хурлын явцад тэмдэглэл хөтлөх, гарсан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлыг Зөвлөлийн даргаар ажиллаж байгаа аймаг, нийслэлийн ЗДТГ хариуцна.

### **Гурав. Бусад зүйл**

3.1 Зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх бөгөөд, хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол зохих журмын дагуу хувийн өмчийн аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаас, санхүүгийн дэмжлэг авч болно.

3.2 Зөвлөл нь Бүсийн зөвлөлийг дэмжих санд хөрөнгө хуримтлуулах, зарцуулах, хамтарсан гэрээ, хэлэлцээр байгуулах, хэрэгжилтийг зохион байгуулах үйл ажиллагаанд хуулиар олгосон өөрийн эрх хэмжээгээр оролцоно.

3.3 Зөвлөл нь Засгийн газрын байгууллагатай бүсийн хөгжлийн асуудлаар хамтран ажиллана.



3.4 Зөвлөл нь хуулиар эрх олгосны дагуу бүсийн хөгжлийн нийтлэг зорилт арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор улсын төсвөөс олгосон санхүүжилтийг бүс дотроо зохицуулах эрх эдэлнэ.

3.5 Зөвлөл нь бүрэлдэхүүндээ, иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөл байгаагаас шалтгаалахгүйгээр аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах аливаа асуудлыг гагцхүү тухайн шатны хуралтай тохиролцсоны үндсэн дээр хууль тогтоомжид заасан журмын дагуу хэлэлцэж, шийдвэрлэж болно.

3.6 Зөвлөл нь тухайн бүсэд багтах аймаг, хотын алслагдсан байдал, тулгуур төвүүдийн байршил, тэдгээрийн зах зээлийн багтаамж, гадаадын хөрөнгө оруулалтыг тухайн бүсэд татах зэргээс хамааруулан бүсчилсэн хөгжлийн дотоод уялдаа зохицуулалтыг хангахад Зөвлөлд тус дөхөм үзүүлэх чиг үүрэг бүхий Зөвлөлийн орлогч даргыг томилон ажиллуулж болох бөгөөд энэ тухайгаа Үндэсний хороотой урьдчилан зөвшилцсөн байвал зохино.

3.7 Зөвлөл нь хуралд бэлтгэх, хурлын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах, Зөвлөлийн захидал харилцааг шуурхай явуулах зорилгоор аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн даргатай адилсах ажилтныг Зөвлөлийн ажлын албанд томилон ажиллуулж болно. Уг ажилтныг ажиллуулахтай холбогдсон зардлын асуудлыг тухайн бүсэд багтах аймгуудын засга дарга нар харилцан тохиролцсоны үндсэн дээр тамгын газрынхаа батлагдсан төсөвтөө багтаан шийдвэрлэнэ.

